



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 606

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө ашиглах хугацаа, үнийг шинэчлэн  
тогтоож балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 23,926,553.09 (хорин гурван сая есөн зуун хорин зургаан мянга таван зуун тавин гурван төгрөг есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Баянчандмань АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Дагдан, “Баянчандмань АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Б.Мөнхгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

• 132007007

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн  
606 дугаар тогтоолын хавсралт



"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "БАЯНЧАНДМАНЬ АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТ" ТӨРИЙН  
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины нэр, улсын дугаар	Ашиглалтанд орсон огноо	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоосон үнэ	Цаашид ашиглах хугацаа
			(төгрөг)	(жил)	
1	Ландкрузер 100, 07-99 УНН	2010/02/28	23,926,553.09	12,000,000.00	6
Нийт дүн			23,926,553.09	12,000,000.00	6
			(хорин гурван сая есөн зуун хорин зургаан мянга таван зуун тавин гурван төгрөг есөн мөнгө)	(арван таван сая)	-